

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тухай хуульд “эдийн засаг, төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн албадыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах”, “төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах” нь Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх гэж заасан.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан “Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна”, “... төрийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж, нээлттэй хувьцаат компани болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх” зорилт дэвшүүлсэн.

Иймд дээр дурдсан чиг үүрэг, зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн холбогдох эрх бүхий албан тушаалтнууд (гүйцэтгэх удирдлага болон нягтлан бодох бүртгэл, худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтнууд)-д зориулан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн хөрөнгө, өр төлбөрийн удирдлага, худалдан авах ажиллагаа, бүртгэл тайлагнал, дотоод хяналт” сэдвээр цахим сургалт зохион байгуулахаар хөтөлбөрийн төслийг боловсруулан танилцуулж байна.

БАТЛАВ.
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Ж.ГАНБАТ

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДАД ЗОРИУЛСАН
ЦАХИМ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

№	Сэдэв	Хариуцах эзэн	Хугацаа
1.	Нээлт	Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат	10:00-10:05
2.	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн хөрөнгө, өр төлбөрийн удирдлага, цаашид баримтлах бодлого	Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир	10:05-11:30
3.	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналт	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга Б.Болормаа	11:30-12:30
4.	Завсарлага		12:30-13:30
5.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны анхаарах асуудлууд	Хууль, эрх зүйн газрын Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн ахлах шинжээч Л.Амгалан	13:30-14:20
6.	Төрийн болон орон нутгийн өмчит компанийн шинэчлэл: Ногдол ашгийн бодлогын шинэчлэл	Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн	14:20-15:10
7.	Үр дүнтэй дотоод хяналтын тогтолцоо	Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Санхүүгийн хяналт, шалгалтын хэлтсийн дарга Ж.Цогтбаяр	15:10-15:50
8.	Хаалт	Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир	15:50-16:00

Жич: Сургалт 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 10.00-16.00 цагийн хооронд цахим хэлбэрээр явагдана.